

# НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ТАЙЛАН

/2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар/

2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

Тус байгууллага нь дараах хууль эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Үүнд:

1. Төрийн захиргааны байгууллагынхаа хувьд өдөр тутмын үйл ажиллагаанд:
  - a. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
  - b. Төрийн албаны тухай хууль
  - c. Захиргааны ерөнхий хууль
  - d. Хөдөлмөрийн тухай хууль
  - e. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
  - f. Авилгын эсрэг хууль
  - g. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөх урьдчилан сэргийлэх тухай хууль
  - h. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
  - i. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
  - j. Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд гарсан бусад эрх зүйн актууд
2. Үндсэн үйл ажиллагаанд:
  - a. Автотээврийн тухай хууль
  - b. Иргэний хууль
  - c. Төрийн хяналт, шалгалтын тухай хууль
  - d. Зөрчлийн тухай хууль
  - e. Ахмад настны тухай хууль
  - f. Боловсролын тухай хууль
  - g. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
  - h. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
  - i. Эдгээр хуулиудыг мөрдөхтэй холбогдон гарсан бусад эрх зүйн актууд

Байгууллагын дүрмийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/88 дугаар захирамжаар шинэчлэн батлуулж мөрдөн ажиллаж байна.

Нэг. Боловсруулан гаргасан баримт бичгийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянах чиглэлээр

Тус газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн хуулийн зөвлөхөд нийт 70 албан бичгийг төлөвлөж шийдвэрлэсэн. Үүний 39 нь <https://edoc.ulaanbaatar.mn> цахимаар ирсэн алба бичиг бөгөөд тухай бүр хуулийн хугацаанд холбогдох хариуг боловсруулж албан бичиг хүргүүлж ажилласан.

Захирамжлалын баримт бичгийн хувьд тус газарт нийт 190 тушаал гарснаас 63 үндсэн үйл ажиллагааны, 127 хүний нөөцийн холбогдолтой тушаал батлан гаргасан. Эдгээр баримт бичгүүдийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, санал өгч боловсруулахад оролцсон.

### **Хоёр. Байгууллагын дотоодод мөрдөх дүрэм, журам, тушаалын төсөл болон албан бичиг боловсруулах чиглэлээр**

Газрын даргаас батлан гаргасан дараах дүрэм, журам, тушаалын төслийг боловсруулсан. Үүнд:

- “Албан ажлын зайлшгүй шаардлагаар авто машин ашиглах журмыг шинэчлэн батлах тухай” А/01 тушаал
- “Шуурхай зөвлөгөөний журмыг шинэчлэн батлах тухай” А/11 тушаал
- “Нийтийн тээврийн үйлчилгээний тэргүүний аж ахуйн нэгж байгууллага ажилтан” А/20 тушаал
- “Зохион байгуулалтын бүтэц, ажил мэргэжлийн жагсаалт шинэчлэн батлах тухай” А/24 тушаал
- “Зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагааны чиг үүргийг шинэчлэн батлах тухай” А/25 тушаал
- “Нийтийн тээврийн төлбөр хураалтын бүртгэл, хяналт, мэдээлэл төлбөр хураалтыг гүйцэтгүүлэх гэрэг дүгнэж, гэрээний төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” А/49 дүгээр тушаал
- “Дотоод хяналт, шалгалт явуулах ажлын хэсэг байгуулах тухай” А/64 тушаалын төслийг боловсруулан ажиллалаа.

Тус газрын дээд шатны байгууллага болох Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичигт тухай бүрт хариу хүргүүлж, шаардлагатай арга хэмжээний талаар судалгаа, тайлан, хэрэгжилт, дүрэм журамд өгөх саналыг тус тус холбогдох албан тушаалтанд мэдэгдэн хүргүүлэв.

### **Гурав. Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай харьяа дээд шатны байгууллагын баримт бичигт өөрчлөлт оруулах санал боловсруулах, гэрээ хэлцлийн төсөл боловсруулж, байгуулах**

#### **1. Харьяа дээд шатны байгууллагын баримт бичигт өөрчлөлт оруулах санал боловсруулах**

2023 оны нэгдүгээр улиралд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 6/21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагч, оюутанд нийтийн тээврийн цахим төлбөрийн карт олгох, цэнэглэх, ашиглахад баримтлах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг Нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлж ажилласан. Мөн Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаан 15 удаа хуралдаж 86 үүрэг даалгавар өгсөнг тухай бүр тайлагнасан.

## 2. Байгууллагын дотоод болон гадаад үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцэл

Нийтийн тээврийн газар болон бусад холбогдох байгууллагуудтай байгуулсан гэрээний төслийг бэлтгэн түүний биелэлтийг ханган ажиллах талаар дараах гэрээний төслийг боловсруулсан. Үүнд:

- Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зардлыг санхүүжүүлэх гэрээ
- Нийтийн тээврийн газрын нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх ЕС зөвшөөрөл, нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачаа авто машиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл олгох үйлчилгээний гэрээ
- Цэвэрлэгээ, үйлчилгээ үзүүлэх гэрээ /Нийтлэг үйлчилгээний газар/
- Бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ
- Чингис хаан олон улсын нисэх буудлаас Улаанбаатар хотын чиглэлд өндөр зэрэглэлийн таксийн үйлчилгээ гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэх гэрээ
- Сургуулийн автобусаар хүүхэд тээвэрлэх үйлчилгээ эрхлэх гэрээ
- Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан тээвэрлэлтийн гэрээг шинэчлэн боловсруулж ажиллалаа.

### **Дөрөв. Ажлын хэсэг, төсөл арга хэмжээнд оролцож санал өгсөн талаар**

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 03/2483 тоот “Санал, судалгаа ирүүлэх тухай” албан бичиг ирүүлсний дагуу Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа талаарх эрсдэлд суурилсан дүн шинжилгээ, бодлогын баримт бичигт тусгах санал, хийсэн ажлын тайланг 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02/01/965 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.

Нийтийн тээврийн санхүүжилттэй холбоотой “Авто зогсоолын тухай хууль”, “Түгжрэлийн тухай хууль”-ийн төсөлд нийтийн тээврийн газрыг төлөөлөн холбогдох саналыг хүргүүлж ажилласан байна. Мөн Оюутны автобусны цахим карттай холбоотой асуудлаар Нийслэлийн засаг даргын хуралдааны тэмдэглэлийг боловсруулж, төслийг 2023 оны 03 дугаар сарын 15нд Нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлж ажиллалаа.

### **Тав. Хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай маргаантай асуудлуудад байгууллагын төлөөллийг хэрэгжүүлэх**

2023 оны хагас жилийн байдлаар хууль хяналтын байгууллагаар дараах маргааныг шийдвэрлүүлсэн байна. Үүнд

- Тус газарт холбогдох Э.Эрдэнэтуяагийн нэхэмжлэлтэй хөдөлмөрийн маргааны 3 удаагийн шүүх хуралд оролцсон. 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар нэхэмжлэгч нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас

нотлох баримт шаардаж, хойшлуулах хүсэлт өгснөөр хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагаа хойшилж шийдвэрлэгдсэн байна.

- “Ситибаз” ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийтийн тээврийн газар, Нийслэлийн Засаг дарга нарт холбогдох захиргааны гэрээтэй холбоотой хэрэг нь Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн танхимд 2023 оны 03 дугаар сарын 29-ний хянан хэлэлцэгдсэн. Тус хэрэгт байгууллагыг төлөөлөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн байна.
- Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянан хэлэлцэгдсэн Т.Анар нэхэмжлэлтэй Байгаль орчин аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг Даргын тамгын газар, Богдхан уулын хамгаалалтын захиргаа, Нийслэлийн Нийтийн тээврийн газарт холбогдох Захиргааны актыг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай хэрэгт байгууллагыг төлөөлөн оролцсон. Тус хэргийн 2023 оны 05 дугаар сарын 29-ний хурлаар нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн байна.

*Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох ажлын хүрээнд:*

- “Жоншт-Уул” ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн засаг даргын Тамгын газарт холбогдох зөвлөх үйлчилгээний гэрээний төлбөрт 428.347.500 төгрөг гаргуулах тухай маргаан нь Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж тус шүүхийн шүүгчийн 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 182/ШШ2023/01347 шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Тус хэрэгт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг төлөөлөн Нийслэлийн Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

### **Зургаа. Иргэд болон албан хаагчдаас цаасан хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдлын хууль, эрх зүйн асуудлыг хянаж шийдвэрлэх ажлын хүрээнд**

Тайлант хугацаанд 1 иргэн, 1 аж ахуйн нэгжээс өргөдөл гомдол ирүүлсэн байна. Иргэн З.Бат-өлзий нь ахмадын бүртгэлд хамрагдах тухай хүсэлтийг ирүүлсэн бөгөөд холбогдох хариуг хүргүүлж ажилласан. Номин трейдинг ХХК-иас ачааны авто машины зөвшөөрөл олгохтой холбоотой хүсэлтийг цахимаар ирүүлсэн ба хууль эрх зүйн асуудлыг хянаж шийдвэрлэсэн.

### **Долоо. Хууль эрх зүйн чиглэлээр сургалт, уулзалт**

2023 оны 02 дугаар сарын 15, 16, 17, 18-ны өдрүүдэд тус байгууллагын хяналт шалгалтын хэлтсийн орлого төвлөрүүлэлтийн тасгийн шалгагч нарт ажилтан, ажил олгогчын эрх үүргийн талаарх сургалтыг, 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэдэг 18 байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүдэд хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлт, өөрчлөлтийн талаарх сургалтыг тус зохион байгуулж ажилласан.